

ЗӨВЛӨМЖ

2019 оны 08 дугаар сарын 08-ны өдөр

Улаанбаатар хот

Нөхцөл байдал 1: Нийслэлийн Орон сууцны корпорациас нийслэлийн зорилтот бүлгийн иргэдийг 972 айлын орон сууцанд хамруулах бүртгэлийн үйл ажиллагааг 2019 оны 07 дугаар сарын 22-ны өдрөөс 08 дугаар сарын 05-ны өдрийг хүртэл цахим хэлбэрээр явуулж, нийт **35 058** иргэн цахим бүртгэлд хамрагджээ. Залуу гэр бүл гэсэн ангилалд **4 443**, төрийн албан хаагч гэсэн ангилалд **6 542**, хувийн байгууллагад ажиллагсад болон хувиараа хөдөлмөр эрхлэгч гэсэн ангилалд **9 549**, 18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүл гэсэн ангилалд **960**, өрх толгойлсон эцэг/эх гэсэн ангилалд **3 148**, ахмад настан гэсэн ангилалд **7 166**, Хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон түүнийг халамжилдаг гэр бүл гэсэн ангилалд **3 134**, Гамшигт аюул үзэгдлийн улмаас орон гэргүй болсон иргэд гэсэн ангилалд **116** иргэн тус тус бүртгүүлсэн гэх мэдээллээс **өөр мэдээлэл Нийслэлийн орон сууцны корпорацийн цахим хуудсанд байхгүй байна.**

Зөвлөмж 1. “Буянт-Ухаа 2” 972 айлын түрээсийн орон сууцанд хамрагдахаар бүртгүүлсэн нийт 35 058 иргэний хувийн нууцад хамаарахаас бусад мэдээлэл (өөрийн нэр, эцэг/эхийн нэр, бүртгүүлсэн огноо, бүртгэлийн дугаар г.м)-ийг зорилтот бүлгийн ангиллаар нь ил тод мэдээлж, цахим хуудсандаа байршуулах, иргэд, олон нийт танилцах боломжоор хангах;

Нөхцөл байдал 2: Бүртгэлийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулсан нь сайшаалтай хэдий ч түрээсийн орон сууцны тоо, зорилтот бүлгийн ангилал, квот, иргэдэд тавигдах шаардлага, бүрдүүлэх материал, бусад шаардлагатай өгөгдлүүд нь ойлгомжтой, тодорхой тохиолдолд аль болох хүний оролцоогүйгээр техник, технологийн оновчтой шийдлийг ашиглан шууд эрэмбэлэх, түүнийгээ олон нийтэд нээлттэй байдлаар зохион байгуулах боломжтой юм. Ингэснээр иргэд сонгон шалгаруулалтыг үйл явцын талаарх бодит мэдээллийг тухай бүрт нь хүлээн авахаас гадна давхар хяналт тавих нөхцөл бүрдэнэ.

Зөвлөмж 2. Сонгон шалгаруулалтын үйл явцад иргэд, олон нийтийн зүгээс хяналт тавих нөхцөлийг бүрдүүлэх:

- түрээсийн орон сууцанд хамрагдахаар хүсэлтээ өгсөн иргэн бүртгэлд авагдсан мэдээллээрээ хэрхэн эрэмбэлэгдсэн;
- бичиг баримтын бүрдлийн шаардлага хангасан эсэх;
- бичиг баримтын бүрдлийн шаардлага хангаагүй бол холбогдох тайлбар;
- шалгарсан шалгараагүй талаарх мэдээлэл;
- сонгон шалгаруулалтын үргэлжлэх хугацаа г.м

Зөвлөмж 3. Иргэдээс шаардлагатай бичиг баримтыг хүлээн авахдаа дараалал үүсгэж иргэдийг чирэгдүүлэхгүй байх, эмх замбараагүй байдал бий болохоос урьдчилан сэргийлж материалыг аль болох олон суваг (нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүд, нийслэлийн дүүргүүдийн ЗДТГ-ын нэг цэгийн үйчилгээ)-аар хүлээн авах, уг үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, лавлагаа, тодорхойлолт олгох чиг үүрэг бүхий үйлчилгээний байгууллага (хороо, дүүрэг, нийслэлийн ЗДТГ, иргэний болон эд хөрөнгийн эрхийн бүртгэл, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, нийгмийн даатгал, татварын байгууллага г.м)-уудын үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ авах;

Зөвлөмж 4. Материал хүлээн авах болон сонгон шалгаруулах үүрэг бүхий комисст ажиллаж буй албан хаагч, албан тушаалтан, эрх бүхий байгууллага нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2¹, 8.4², 8.6³-д заасан үүргээ биелүүлж ажиллах, мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.5⁴-д заасан зөвлөмжийг өгөх, авлига, ашиг сонирхлын шинжтэй зөрчил илэрсэн тохиолдолд АТГ-т нэн даруй мэдэгдэх⁵;

Зөвлөмж 5. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 114 дүгээр тогтоолоор баталсан “Нийслэлийн зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам”-ын 5.2.1.6, 5.2.2.5, 5.2.3.4, 5.2.4.5, 5.2.5.5, 5.2.6.4, 5.2.7.5, 5.2.8.4-д заасан “**бусад**” гэх тодотголтой тодорхой бус заалт нь олон нийтийг төөрөгдүүлэх, албан тушаалтныг авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөх эрсдлийг бий болгож болзошгүй байх тул журамд өөрчлөлт оруулах саналыг эрх бүхий этгээдэд тавьж, шийдвэрлүүлэх.

Мөн журмын 2.2-т сонгон шалгаруулалтаас хасагдсан иргэнийг “хар жагсаалт”-д оруулахаар тусгасан нь журмын 1.5.15-д заасан нэр томъёоны тодорхойлолтын агуулгад нийцэх эсэхийг дахин нягтлах, тодорхойлолтыг эргэж харах.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

¹ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2. Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

² Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4. Ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдэгдэл, мэдээлэл хүлээн авсан эрх бүхий байгууллага, албан тушаалтан тухайн албан үүргийг өөр албан тушаалтнаар гүйцэтгүүлэх эсэх шийдвэрийг нэн даруй бичгээр гаргана.

³ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6. Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл тухайн албан тушаалтан уг нөхцөл байдалд бичгээр тайлбар хийж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

⁴ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2. Төрийн байгууллагын удирдлага ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээг авах үүрэгтэй: 7.2.5. ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй албан тушаалтанд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг арилгах талаар бичгээр зөвлөмж өгөх;

⁵ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3. Энэ хуулийн 7.2.2, 7.2.3-т заасан шалгалтын явцад авлигын шинжтэй зөрчил илэрсэн бол Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн шалгуулна.